



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/37

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хүндэт шагналын тэмдэг, фото альбом, бэлэг дурсгалын зүйл хийх зардалд 20.0 сая /Хорин сая / төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулагдах 20.0 сая төгрөг /Хорин сая/-ийг аймгийн орон нутгийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний жагсаалтын 3.12-д заасан арга хэмжээнээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/ нарт зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/ -д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Аймгийн Засаг даргын 2020 оны  
01 дүгээр сарын 31-ний өдрийн  
А/37 дугаар захирамжийн хавсралт



### АЙМГИЙН “БРЕНД” СУВИНЕР ХИЙЛГЭХ АЖЛЫН ТӨСӨВ

Д/д	Зардлын төрөл зүйл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Дүн /мян.төг/
1	Аймгийн Фото альбом хэвлүүлэх	ш	500	15.000	7 500.0
2	Аймгийн бренд сувинер хийлгэх	ш	500	12.500	6 250.0
3	“Ховдын төлөө медаль” захиалан хийлгүүлэх	ш	100	11.000	1 100.0
4	Аймгийн “Хүндэт тэмдэг” захиалан хийлгэх	ш	200	11.000	2 200.0
5	Аймгийн удирдах ажилтаны дэвтэр бал захиалан хэвлүүлэх	ком	400	6.000	2 400.0
6	Тээврийн зардал	кг	1.100	500	550.0
	Нийт дүн				20 000.0